

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад дагалдан гарах хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад дагалдан гарах хуулийн төслүүдийг 2025 оноос хэрэгжүүлэхээр шаардагдах зардлыг дараах төрөл тус бүрээр тооцлоо:

- Ахмад настны нийгмийн халамжийн чиглэлийн зардлын өнөөгийн байдал
- Нийгмийн халамжийн санд үүсэх зардал;
- Төрийн байгууллагад үүсэх зардал;
- Хуулийн этгээдэд үүсэх зардал;
- Иргэнд үүсэх зардал.

Түүнчлэн зардлыг тооцоходоо 2023 оны халамжийн сангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг суурь болгон авсан.

А/Ахмад настны нийгмийн халамжийн чиглэлийн зардлын өнөөгийн байдал

Ахмад настанд төрөөс үзүүлж байгаа нийгмийн хамгааллын үйлчилгээний зардал нь Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Алдар цолтой ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулиудын хүрээнд Нийгмийн халамжийн сангаас болон улсын төсвөөс үйлчилгээ үзүүлж байна.

№	Тусламж үйлчилгээний төрөл	Зохицуулж байгаа хууль тогтоомж	Хүний тоо /2022, 2023/	Давтамж /2023/	Зардлын хэмжээ (Тэрбум төг)
1	Ахмад настны нийгмийн халамжийн тэтгэвэр	Нийгмийн халамжийн тухай	6582	Сар бүр 325000	22.8
2	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний тэтгэмж	Нийгмийн халамжийн тухай	35200	Сар бүр 275000	61.5
3	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настанд улиралд нэг удаа олгож байгаа тэтгэмж	Нийгмийн халамжийн тухай	31000	улиралд нэг удаа 60000	6.2
4	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ				
4.1	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	Нийгмийн халамжийн тухай	2300	Тухай бүр	0.71
4.2	Өдрийн үйлчилгээнд хамруулах		1100		0.148

4.3	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах		230		0.57
5	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний тэтгэмж	Нийгмийн халамжийн тухай	131	Сар бүр 275000	0.17
6	Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	Нийгмийн халамжийн тухай	219	Байнга	0.8
	Улсын асрамж Хувийн асрамж		50		
7	Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд ахмад настанд зарцуулж байгаа нийт зардал		76993		92.9
8	Алдар цолтон ахмад настанд үзүүлэх нэмэгдэл	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай	2600	Сар бүр	6.5
9	Алдар цолтон ахмад настанд дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай	653	Жилд нэг удаа	0.25
10	Алдар цолтон ахмад настанд нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг нэг удаа олгох		560	Жилд нэг удаа	0.3
11	Алдар цолтон ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох		2500	Жилд нэг удаа	0.4
12	Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн хүүхдийг урамшуулах тухай	134000		17.0
13	Насны хишиг	Ахмад настны тухай	175000		27.1
14	Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ • лавлагаа, мэдээллийн үйлчилгээ;	Ахмад настны тухай	2366		0.6

	<ul style="list-style-type: none"> • зөвлөгөө өгөх үйлчилгээ; • явуулын үйлчилгээ; • өдрийн үйлчилгээ; • сайн дурын үйлчилгээ; • өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ; • асрамжийн үйлчилгээ; • хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ; <p>гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ.</p>				
15	хөл, гарын протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг таван жилд нэг удаа, шүд /үнэт металлаар хийхээс бусад/-ний протезийн дотоодод хийлгэсэн зардлын үнийг гурван жилд нэг удаа тус тус нийгмийн халамжийн, эсхүл эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олгох;	Ахмад настны тухай	50200		7.7
16	Ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгох;	Ахмад настны тухай	49913		8.2
17	эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;	Ахмад настны тухай	39300		5.7
18	Нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын	Ахмад настны тухай	3000		0.5

	шийдвэрээр нийслэлд эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн болон нэгдсэн эмнэлэг тухайн ахмад настанд дараалал харгалзахгүй үйлчилж, унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;				
19	тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;	Ахмад настны тухай	4150		0.6
17	нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох;	Ахмад настны тухай	33		0.02
18	ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих бөгөөд нийтийн тээврийн байгууллага ахмад настныг нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;	Ахмад настны тухай			
19	ахмад настанд олгох нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийг харьяа аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх.	Ахмад настны тухай			
20	Ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан болон бусад	Ахмад настны тухай	128037		2.1

	шалтгаанаар харьяалах аж ахуйн нэгж, байгууллага байхгүй болсон ахмад настныг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан бүртгэж Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.				
21	Хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	Ахмад настны тухай	1200		0.16
22	Хүндэт донор ахмад настан дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	Ахмад настны тухай	177		0.12
Ахмад настны тухай хуулийн хүрээнд зарцуулж байгаа зардал			453376		52.8
Нийгмийн халамжийн тухай			76993		92.9
Алдар цолтой болон ахмад одонтой ээжийн зардал			140313		24.5
НИЙТ ЗАРДАЛ /ахмадуудын тоо олон төрлийн үйлчилгээнд хамрагдсанаар давхацсан/			670682		170.2

2017 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Ахмад настны тухай хуулийн хүрээнд ахмад настны хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, үйлчилгээг хөгжүүлэх, ахмад настны хэрэгцээнд түшиглэсэн үндэслэн лавлагаа, мэдээллийн зөвлөгөө өгөх, сургах, хөгжүүлэх, явуулын үйлчилгээ болон өдрийн үйлчилгээ, өдрөөр эмчлэх, асрах сувилал үйлчилгээ зэрэг шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, хувийн хэвшил, төрийн бус байгууллага нь асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэхэд төрөөс дэмжих асуудлыг тусгасан ч энэ шинэ үйлчилгээний хэрэгжилт тун хангалтгүй байна. Тухайлбал Ахмад настанд зориулсан нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, насны хишиг, одонгийн мөнгө гэх мэт мөнгөн шилжүүлэгт 144.0 тэрбум төгрөг (2024 онд асаргааны тэтгэмжийн нэмэгдэлтэй 192 тэрбум болно), рашаан сувилал, амралт, протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд 23.4 тэрбум төгрөг зарцуулж байна. Харин ахмад настны нийгмийн хөгжил оролцоог дэмжих шинэ төрлийн үйлчилгээнүүдэд Ахмад

настны хуулиар 2022 оны байдлаар 2300 хүнд 0.6 тэрбум, Нийгмийн халамжийн тухай хуулиар олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд 3000 гаруй хүнд 0.8 тэрбум төгрөг зарцуулж байна. Ахмад настны нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулж байгаа нийт 220.0 гаруй тэрбум төгрөгийн /2024 оны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлүүдийг нэмж тооцоод/ 0.3 хувь хүрэхгүй зардлыг л ахмад настны хөгжил, оролцоог дэмжих хувийн хэвшил, ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээнд зарцуулж байна.

Энэ байдал нэг талаас хуулийг хэрэгжүүлэх журам, дүрэм, аргачлал муу боловсруулагдсан, хувийн хэвшил, төрийн бус байгууллагыг чадавхжуулаагүй, шинэ үйлчилгээг бий болгоход төрийн байгууллагууд ч, ТББ-ууд ч туршлага, чадавх сул, нөгөө талаас батлагдсан хуульд ч дээрх үйлчилгээг үзүүлэх төрийн байгууллагуудын уялдаа холбоо, санхүүжилтийн механизмыг сул байгаатай холбоотой байна.

Үнэндээ Монгол Улсад ахмад настнуудын хувьд рашаан сувилал, амралт, Батсүмбэрийн болон цөөн хэдэн төвлөрсөн асрамжийн газраас өөр ахмад настныг сувилах, дэмжих, хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах, сэргээн засах зэрэг бусад дэмжлэг үйлчилгээ байхгүйтэй адил байна.

Иймд хуулийн төсөлд ахмад настны хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор Ахмад настны тухай хуулийн “13.7.Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нь нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгөний 10 хувиас багагүй байна.” гэсэн хэсэг байна.

Б/ Нийгмийн халамжийн санд үүсэх зардал;

1. Үйлчилгээ

Ахмад настны хөгжил оролцоог дэмжих үйлчилгээнд 2022 оны байдлаар 2300 хүнд 0.6 тэрбум төгрөг зарцуулсан нь энэ үйлчилгээ байхгүйтэй адил байна гэсэн үг юм.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хөрөнгө төсөвлөхгүй байх нь үйлчилгээг хөгжүүлэхгүй байх үндсэн шалтгаан болж байна.

Иймд нийт ахмад настны ядаж 20-30 хувийг 90000 ахмад настныг хамруулахаар тооцож, дунджаар 68000 ахмад настныг хамруулахад 20.0 тэрбум төгрөг, мөн Эрүүл мэндийн даатгалаас 5.0 тэрбум төгрөг, Орон нутгийн төсвөөс 5.0 тэрбум төгрөг зарцуулах ба үүнд 7.1.7-д заасан хувилбарт үйлчилгээ буюу асрамжийн үйлчилгээний зардал багтсан юм.

Үйлчилгээний зардлын санхүүжилтийг олон эх үүсвэрээс буюу тухайлбал, нийгмийн халамжийн сан буюу улсын төсвөөс 60 хувь, Эрүүл мэндийн даатгалын сангаас 20 хувь, Орон нутгийн төсвөөс 10 хувь, иргэнээс 10 хувийг зарцуулахаар зохицуулж болно. Хуулийн төсөлд санхүүжилт үнэ тарифтай холбоотой зохицуулалтыг хэн батлахыг заасан. Эрүүл мэндийн даатгалын хувьд сэргээн засах үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ зэрэг үйлчилгээний зардлыг хууль тогтоомжийн дагуу хариуцахаар тусгасан.

Ахмад настанд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэн, санхүүжилтийг үүнд зарцуулснаар бэлэн мөнгөний тэтгэмж, тусламжтай харьцуулахад иргэн, аж ахуйн нэгж, ТББ-ын оролцоог нэмэгдүүлж, улмаар ажлын байр нэмэгдэх, нийгэм эдийн засгийн ач холбогдолтой байдаг.

Ингэснээр ахмад настны асрамж, халамж, нийгмийн оролцоо, сэргээн засах болон бусад төрлийн ахмад настанд зориулсан үйлчилгээг сайжруулснаар ахмад насны эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирч, хэвтэн эмчлүүлэх болон эмийн зардал буюу эрүүл мэндийн одоогийн үйлчилгээний зардал аажмаар буурах боломжтой.

2/Орон сууц, түлшний үнийн хөнгөлөлт

Ахмад настны тухай хуулийн 8.1.3-т тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд түлшний үнийн хөнгөлөлт олгоно гэсэн нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул энэ заалтыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-т заасан өрхийн ахмад настан гэж өөрчлөхөөр тусгасан. ХХҮГ-аас авсан статистикаар Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай /хүнсний эрхийн бичиг авч байгаа ядуу өрх/ нийт 22000 гаруй өрх байгаагаас 5800 нь ахмад настантай байна. Тэдэнд одоо хэмжээ жилд нэг удаа 140000 төгрөг олгож байгаа хэмжээгээр тооцоход 127 сая төгрөг нэмж шаардагдахаар байна.

3/ Ахмад настны тухай хуулийн 10.1.2-т эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн жишиг үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгохоор заасан. Энэ заалтаас рашаан гэснийг хасахад Одоо 39300 ахмад настанд 5.7 тэрбум төгрөг зарцуулж байна. Одоо рашаан сувиллын тоо 20 ширхэг байгаа ба рашаан гэснийг хассанаар магадлан итгэмжлэгдсэн сувиллын тоо 50 орчим болж нэмэгдэнэ. Нийт хүний тоо 98250 болж, шинээр хамрагдах ахмад настны тоо 58950 болно. Тэгвэл нийт зардал 14.25 тэрбум, нэмж шаардагдах төсөв *8.5 тэрбум төгрөг болохоор байна*.

Нийгмийн халамжийн санд энэ хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 28.6 орчим тэрбум төгрөг 2025 оноос нэмж шаардагдах тооцоо гарч байна.

V/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд:

Энэ хуулийн төслийн хүрээнд ахмад настны хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих үйлчилгээг нэмэгдүүлэхээр тусгасан.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь хязгаарлагдмал, хамрагдалт бага байна. Тухайлбал, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2022 онд ахмад настны зөвлөх үйлчилгээнд 848 ахмад хамрагдаж, 707.4 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1,056 ахмад хамрагдаж 4.4 тэрбум төгрөг, хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 346 ахмад хамрагдаж, 303.1 мянган төгрөг буюу нийт 5.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ зардлын 4.4 тэрбум нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл байгаа ба зээлийн дүнг хасвал жилд 1.0 тэрбум төгрөг л ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулж байна.

Хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо 2022 онд 2230 ахмад настан байгаа нь нийт ахмад настантай харьцуулахад маш бага хувийг эзэлж байна. Иймд энэ төрлийн арга хэмжээг нэмж, 20000 орчим ахмад настныг хамруулахаар тооцсон. Одоо ахмад настанд 1.0 тэрбум төгрөг зарцуулж байгаа бол зардлыг 10 дахин нэмэгдүүлж 10.0 тэрбум болгохоор тооцсон. Иймд 2024 онд 5.0 тэрбум орчмыг төсөвлөсөн байгааг дахин 5.0 тэрбум төгрөгөөр нэмж ХЭДСанд зарцуулахаар тооцсон.

Г/Төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардал;

Ахмад настны тухай хуулийн 14.7-д аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулахаар заасан. Ахмадын сан байгуулан ажиллах журмыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан.

Ахмадын сан нь байгууллага, аж ахуйн нэгжид ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болох зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой. Улсын хэмжээнд нийт 9838 аж ахуйн нэгж байгууллага Ахмадын сан байгуулсан байна. Үүнээс :2020 онд 1777, 2021 онд 3534, 2022 онд 4527 байгууллага байна. Цаашид энэ зохицуулалтын хэрэгжилтийг хангахаар төсөвт байгууллага төсөвтөө тусган батлуулах заалт нэмсэн. Одоо Ахмадын сан байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын жил бүрийн гэрээнд тусган ажиллаж байна.

Монгол Улсад 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагын цалингийн сангийн тухайлбал, 1 хувь нь ойролцоогоор жилд **16.5 сая** төгрөг байдаг тул, энэ арга хэмжээ нь аж ахуйн нэгж байгууллагуудад дарамт үзүүлэхгүй гэж тооцож байна.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуультай уялдуулан, ахмад настныг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага ахмад настныг авч ажиллуулсан тохиолдолд ахмад настан хүсвэл тэтгэврийн даатгалын шимтгэл 8.5 хувийг байгууллага төлөхгүй байхаар заасан.

Д/ Иргэнд үүсэх зардал

Ахмад настан одоогийн хуулийн хүрээнд шүдний протез, амралт сувилал, рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд 50 хүртэл хувийг өөрөө хариуцах зохицуулалт байдаг. Хуулийн энэ зохицуулалт хэвээр үргэлжилнэ. Үүнээс гадна Үйлчилгээний зардлыг холбогдох талууд хамтран санхүүжүүлдэг улс орнууд байдаг.Тухайлбал, Японд урт хугацааны асаргааны даатгалаас 50 хувийг, Улсын төсвөөс 25 хувь, орон нутгийн төсвөөс 25 хувь иргэнээс 10 хувийг авдаг байна. Иймд нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээний зарим зардлыг иргэнээс тооцон гаргуулахаар тусгасан. Гэхдээ энэ нь ахмад настны амьжиргааны түвшинтэй уялдан уян хатан байна.

Нөгөө талаар ахмад настны хувилбарт үйлчилгээ гэсэн шинэ үйлчилгээг нэмж, ахмад настны асруулах эрэлт хэрэгцээ, нөхцөл байдалд үндэслэн өдрөөр, түр, урт хугацаанд байрлуулан асрах, байнга асрах төрөлжсөн асрамжийн, асралт гэр бүлээр асруулах, гэрээр асрах зэрэг бусад шаардлагатай үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан эсхүл хамтран төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэх үйл ажиллагааг тусгасан.

Иймд ахмад настан өөрийн сонголтоор олон төрлийн үйлчилгээ, асрамжийн үйлчилгээг авч байгаа үйлчилгээний төрлөөс шалтгаалан төлбөртэй үйлчилгээг сонгож болохоор тусгасан. Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар ахмад настанд төрөөс үзүүлэх дэмжлэг үйлчилгээнд хамрагдах хүний тоо өсч, 43.0 гаруй тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгө шаардагдана.

Харин алдар цолтой ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг сард 400,000 төгрөг, 250,000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлэх УИХ-ын тогтоолын төслийн хүрээнд жилд 4.5 тэрбум төгрөг нэмж зарцуулагдах тооцоо гарсан.

Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэмж шаардагдах хөрөнгөний 80 гаруй хувь ахмад настны хөгжлийн болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, сэргээн засах зэрэг ахмад настны эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зарцуулагдана.

Ингэснээр ахмад настны урт хугацааны асаргаа үйлчилгээ, эрүүл насжилтыг дэмжиж, эрүүл мэнд, нийгмийн оролцоо сайжирч улмаар эмнэлэгт хэвтэх, эм худалдан авах зэрэг эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний зардал аажмаар буурах эерэг нөлөөтэй юм. Мөн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх үйлчилгээг дэмжсэнээр ахмад настны болон мэргэжлийн байгууллагуудын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засагт сайнаар нөлөөлнө.

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО /Тэрбум төгрөг/**

Хуулийн заалт	Шинээр нэмж хамрагдах хүний тоо	Нэмж шаардагдах хөрөнгө жилд	Тайлбар
<p>7 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ</p> <p>7.1.Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна:</p> <p>7.1.1.лавлагаа, мэдээллийн үйлчилгээ;</p> <p>7.1.2.зөвлөгөө өгөх үйлчилгээ;</p> <p>7.1.3.явуулын үйлчилгээ;</p> <p>7.1.4.өдрийн үйлчилгээ;</p> <p>7.1.5.сайн дурын үйлчилгээ;</p> <p>7.1.6.өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ;</p> <p>7.1.7.<u>ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ;</u></p> <p>7.1.8.хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ;</p> <p>7.1.9.гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ.</p> <p>7.1.10.<u>ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ;</u></p> <p>7.1.11.<u>ахмад настны дасгал, хөдөлгөөн, эрүүл мэнд, нийгмийн оролцоог дэмжих үйлчилгээ;</u></p> <p>7.1.12.<u>ахмад настанд үзүүлэх сэргээн засах үйлчилгээ;</u></p>	<p>Энэ төрлийн үйлчилгээнд 2022 оны байдлаар 2300 хүнд 0.6 тэрбум төгрөг зарцуулсан нь энэ үйлчилгээ байхгүйтэй адил байна гэсэн үг юм.</p> <p>Нийт ахмад настны ядаж 30 хувийг хамруулах</p> <p>Үүнд: Дунджаар 90000 ахмад настныг хамруулах</p>	<p>Үүнд: Дунджаар 68000 ахмад настныг хамруулахад 20.0 тэрбум төгрөг,</p> <p>Үүнд 7.1.7-д заасан хувилбарт үйлчилгээ буюу асрамжийн үйлчилгээний зардал багтсан.</p> <p>Эрүүл мэндийн даатгалаас 5.0 тэрбум төгрөг,</p> <p>Орон нутгийн төсвөөс 5.0 тэрбум төгрөг</p>	<p>Санхүүжилтийг тодорхой болгож, төсвийг нэмэгдүүлэх.</p> <p>Үйлчилгээний зардлыг холбогдох талууд хамтран санхүүжүүлдэг улс орнууд байдаг.</p> <p>Тухайлбал, Японд урт хугацааны асаргааны даатгалаас 50 хувийг, Улсын төсвөөс 25 хувь, орон нутгийн төсвөөс 25 хувь иргэнээс 10 хувийг авдаг байна.</p> <p>Манайд ч ийм байх боломжтой ба тухайлбал, улсын төсвөөс 60 хувь, Эрүүл мэндийн даатгалаас 20 хувь, Орон нутгийн төсвөөс 10 хувь, иргэнээс 10 хувийг зарцуулахаар зохицуулж болно.</p> <p>Үйлчилгээг хөгжүүлэх ажлуудыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <p>Одоогийн байдлаар Ахмад настны тухай хуулийн хуулийн 7.1-д заасан үйлчилгээнд 0.6 тэрбум, 8.1.1-д заасан протез, ортопедийн үйлчилгээнд 7.7 тэрбум, 8.1.2 амралт сувилалд 8.2 тэрбум , 10.1.2-т заасан</p>

<p><u>13.5.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ, 8.1.1, 8.2.2, 10.1.2-т заасан дэмжлэгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, орон нутгийн төсвөөс болон ахмад настны оролцоотойгоор санхүүжүүлнэ.</u></p> <p><u>13.6.Энэ хуулийн 13.5-д заасан үйлчилгээний жишиг үнэ, төлбөр, хөнгөлөлтийн хэмжээ, эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн халамжийн болон орон нутгийн төсвөөс хариуцах санхүүжилт болон иргэний хариуцах төлбөрийг нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.</u></p> <p><u>13.7.Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нь нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгөний 10 хувиас багагүй байна.</u></p> <p><u>13.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настанд зарцуулах хөрөнгө нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн зардлыг оруулахгүйгээр тус сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.</u></p> <p><u>13.9.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-9.1.6-т заасан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон боловсролын, эрүүл мэндийн, хөдөлмөрийн, байгаль орчны, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн</u></p>			<p>зашаан сувилалд 5.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс буюу халамжийн сангаас зарцуулж байна.</p> <p>Нийгмийн халамжийн үйлчилгээнд хөрөнгө төсөвлөхгүй байх нь үйлчилгээг хөгжүүлэхгүй байх нэг шалтгаан болж байна.</p> <p>Иймд Энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд зарцуулах хөрөнгө нь нийгмийн халамжийн сангаас ахмад настанд зориулан зарцуулах нийт хөрөнгөний 10 хувиас багагүй хэмжээтэй байна. гэсэн заалт нэмсэн.</p> <p>Сэргээн засах болон бусад төрлийн ахмад настанд зориулсан үйлчилгээг нэмснээр ахмад насны эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирч, хэвтэн эмчлүүлэх болон эмийн зардал буюу эрүүл мэндийн одоогийн үйлчилгээний зардал аажмаар буурах боломжтой.</p>
---	--	--	--

<p><u>үйлдвэрийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.</u></p>			
<p><u>7.8.Төрийн болон орон нутгийн өмчит барилга, байгууламжид байрлаж, энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг үзүүлж байгаа ахмадын өргөө, ахмадын төв, сэргээн засах төв, идэвхтэй насжилтыг дэмжих төв, дасгалын клуб, олон нийтийн төвийн урсгал зардлыг орон нутгийн төсвөөс гэрээний үндсэн дээр хэсэгчлэн болон санхүүжүүлнэ.</u></p>			<p><i>Одоо улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа. Цаашид хувийн байгууллага ийм төвүүд байгуулбал энэ заалтын дагуу зардал гарна.</i></p>
<p>8.1.3.тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон, эсхүл <u>Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-т заасан өрхийн ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж эсхүл түлш худалдан авах эрхийн бичиг олгох;</u></p> <p>;</p>	<p>ХХҮГ-аас авсан статистикаар Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нийт 22000 гаруй өрх байгаагаас 5800 нь ахмад настантай байна.</p> <p>Хэмжээг одоо олгож байгаа хэмжээ жилд нэг удаа 140000 төгрөг байгаа тул энэ хэмжээгээр тооцсон.</p>	<p>Нэмж шаардагдах зардал:</p> <p>127.6 сая төгрөг</p>	<p>Жилд нэг удаа 140000 гэдэг нь 2012 онд тогтоосон хэмжээ бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатай.</p>

<p><u>9.1.4.хөдөлмөрийн, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран ахмад настан боловсролын байгууллагад ажиллах, насан туршийн боловсрол олгох чиглэлээр ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</u></p>	<p>Одоо 2230 байгааг нэмэгдүүлж багадаа 20000 орчим болгох шаардлагатай.</p>	<p>2230 орчим ахмад настанд 1.0 тэрбум төгрөг зарцуулж байгаа бол зардлыг 10 дахин нэмэгдүүлж 10.0 тэрбум</p>	<p>Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь хязгаарлагдмал, хамрагдалт бага байна. Тухайлбал, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2022 онд ахмад настны зөвлөх үйлчилгээнд 848 ахмад хамрагдаж, 707.4 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1,056 ахмад хамрагдаж 4.4 тэрбум төгрөг, хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 346 ахмад хамрагдаж, 303.1 мянган төгрөг буюу нийт 5.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ зардлын 4.4 тэрбум нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл байгаа ба зээлийн дүнг хасвал жилд 1.0 тэрбум төгрөг л ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулж байна. Хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо 2022 онд 2230 ахмад настан байгаа нь нийт ахмад настантай харьцуулахад маш бага хувийг эзэлж байна.</p>
<p><u>9.1.5. хөдөлмөрийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран сэргээн засалтын, идэвхтэй насжилтыг дэмжих болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад ахмад настныг ажиллахыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</u></p>		<p>ХЭДсан жилд 100 гаруй тэрбум төгрөг төсөвлөдөг бол үүний 10 хувь нь 10 тэрбум</p> <p><i>Нэмж шаардагдах 5.0 тэрбум</i></p>	
<p><u>9.1.6.хөдөлмөрийн, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, байгаль орчин, аялал жуулчлалын зэрэг асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран үйлдвэржилтийг эрчимжүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад чиглэлээр УИХ-аас баталсан үндэсний хэмжээний бодлого, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настан хувиараа хөдөлмөр, өрхийн аж ахуй эрхлэхийг техник, технологи, хөрөнгө санхүүгээр дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</u></p>			
<p>9.1.7.энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээг ахмад настан, ахмадын байгууллага, ахмад настны холбоо, сан, хоршоо, ахмадын оролцоотой байгууллага гэрээлэн гүйцэтгэхийг дэмжиж, энэ чиглэлээр хувиараа ажилласан ахмад настны цалин хөлсийг ажилласан цагаар, өдрөөр, сараар тооцон гэрээний дагуу хөдөлмөр эрхлэлтийг</p>			

<p>дэмжих болон хууль тогтоомжийн дагуу бусад холбогдох сангаас санхүүжүүлэх.”</p> <p><u>13.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ахмад настанд зарцуулах хөрөнгө нь эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн зардлыг оруулахгүйгээр тус сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна.</u></p> <p><u>13.9.Энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-9.1.6-т заасан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон боловсролын, эрүүл мэндийн, хөдөлмөрийн, байгаль орчны, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.</u></p>			
<p>10.1.2.эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн <u>жишиг</u> үнийн 50 хувийг, хүндэт донор ахмад настанд 100 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;</p>	<p>Одоо 39300 ахмад настанд 5.7 тэрбум төгрөг зарцуулж байна. Рашаан сувиллын тоо 20 ширхэг байна.</p> <p>Нийт хүний тоо: 98250</p> <p>Шинээр хамрагдах:58950</p>	<p>Нийт зардал 14.25 тэрбум</p> <p>Нэмж шаардагдах : 8.5 тэрбум төгрөг</p>	<p>Рашаан гэсэн үгийг авбал магадлан итгэмжлэгдсэн сувиллын тоо 50 орчим болж нэмэгдэнэ.</p> <p>Тэгэхээр хамрагдах хүний тоо болон зардал 1.5 дахин нэмэгдэнэ.</p>
<p>14.7.Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн</p>	<p>50 хүнтэй байгууллагын</p>		

<p>төсөв, үйл ажиллагааны орлогоосоо, <u>төсөвт байгууллага тухайн жилийн төсвийн зардалдаа тусган</u> цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.</p>	<p>цалингийн сангийн 1 хувь нь ойролцоогоор жилд 16.5 сая төгрөг</p>		
<p>НИЙТ</p>	<p>240488</p>	<p>43.6 тэрбум төгрөг</p>	<p>Нэмэгдэх үйлчилгээ тус бүрд нэмж хамрагдах ахмадуудын нийлбэр тоо</p>

---oOo---